

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

**БАРАА МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: *“Гемодиализийн тасгийн тохижилт, тоног төхөөрөмж /Бүсийн оношилгоо, эмчилгээний төв/” бараа нийлүүлэх*

Төслийн дугаар: ***ОНТ-2.3.9/2020***

**Чойбалсан хот  
2020 он**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020.01.23

Тендер шалгаруулалтын дугаар: ОНТ-2.3.7/2020

Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газар эрх бүхий тендерт оролцогчдоос 11.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй **“Гемодиализийн тасгийн тохижилт, тоног төхөөрөмж /Бүсийн оношилгоо, эмчилгээний төв/”** байгуулахад шаардлагатай бараа нийлүүлэх цахим тендер гүйцэтгэх тухай урилга хүргүүлж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь **цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын** дагуу зохион байгуулж байна.

Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийг **2020 оны 02-р сарын 10-ний өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 02-р сарын 10-ний өдрийн 10 цаг 10 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Эрхгүй**

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Багц1- Тооцохгүй,  
Багц2- Тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Дорнод аймгийн Хэрлэн сумын 10 дугаар баг,  
Аймгийн Засаг даргын Тамгын газрын 3 дугаар байр, 2 дугаар давхар  
Орон нутгийн өмчийн газар  
Утас: 7058-3058  
Факс: 7058-4058  
Цахим шуудан: [Dornodumch@gmail.com](mailto:Dornodumch@gmail.com)  
Цахим систем: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
<p><b>ТӨӨЗ 1.1</b></p>	<p>Тендерт оролцогч нь Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих 11,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй <b>“Гемодиализийн тасгийн тохижилт, тоног төхөөрөмж /Бүсийн оношилгоо, эмчилгээний төв/”</b> бараа нийлүүлэх ажилд дараахь мэдээллийг үнийн саналын хамт ирүүлнэ. Тендерт оролцогч нь “Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь”- заасан барааг нийлүүлэх бөгөөд дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баталгаажуулсан байх/</li> <li>• Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.</li> <li>• Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт,</li> <li>• Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт,</li> <li>• Харилцагч банкны тодорхойлолт,</li> <li>• Авах боломжтой зээл, эргэлтийн хөрөнгийн нийт дүн: Санал болгож буй үнийн дүнгээс <b>50%-иас</b> багагүй байх /банкны тодорхойлолт, дансны үлдэгдэлээр тодорхойлно/,</li> <li>• Тендерийн материалд санхүүгийн тайлангийн мэдээллийг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд Цахим худалдан авах ажиллагааны систем нь Үндэсний татварын ерөнхий газрын татвар төлөгчийн мэдээллийн сан, сангийн яамны e-balance-аас борлуулалтын орлого, татварын өрийн талаарх мэдээллийг шалгана.</li> <li>• Сүүлийн 2 жил буюу <b>2018, 2019 оны</b> борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн <b>80%-иас багагүй</b> байна.</li> <li>• Нийт үнийн <b>50 хувиас</b> багагүй үнийн дүнтэй ижил, төстэй ажлыг 2018, 2019 онд хийж гүйцэтгэсэн байх бөгөөд үүнийг нотлох гэрээ, актыг хавсаргасан байна.</li> <li>• Санал болгож буй техник, тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй үзүүлэлт, тайлбар, зураг.</li> </ul> <p>Оролцогч нь оролцож буй багц тус бүрт дараах нэмэлт материалыг хавсарган ирүүлнэ. Үүнд:</p> <p><b>Багц-1</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Гадаад худалдаа эрхлэх, Тоног төхөөрөмж нийлүүлэх эрхтэй</li> </ul> <p><b>Багц-2</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Мод, модон эдлэлээр үйлдвэрлэл эрхлэх гэрчилгээ,</li> <li>- Шаардлагатай тоног төхөөрөмж,</li> </ul> <p>Тодорхойлолтуудыг тендер зарласан өдрөөс хойш гаргасан байна. Дурдсан мэдээлэл, холбогдох баримтыг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p>

<p><b>ТӨӨЗ 2.1</b></p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:          Байгууллагын хаяг: <i>Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баг,          Аймгийн ЗДТГ-ын 3 дугаар байрны 2 дугаар давхар,          Орон нутгийн өмчийн газар,</i>          Огноо: <i>2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр</i>          Цаг: <i>10 цаг 00 минут</i></p> <p>Тендерг оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба оролцож байгаа тендерийн нэр, дугаарыг гаргацтай тэмдэглэнэ.          Тендерийн материалыг Худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Мб-аас ихгүй байна, нэг файлын хэмжээ 15 Мб-аас ихгүй байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерг оролцох хураамж 50,000 төгрөгийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.</p>
<p><b>ТӨӨЗ 2.1</b></p>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:  <i>Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баг,          Аймгийн Засаг даргын Тамгын газрын 3-р байр, 2-р давхар          Орон нутгийн өмчийн газар          Утас: 7058-3058          Факс: 7058-4058          Цахим шуудан: <a href="mailto:info@umch.dd.gov.mn">info@umch.dd.gov.mn</a>          Цахим хуудас: <a href="http://www.umch.dd.gov.mn">www.umch.dd.gov.mn</a>          Ш/Х-250</i></p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:          Огноо: <i>2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр</i>          Цаг: <i>10 цаг 10 минут</i>  <i>Үнэлгээний хорооны өрөөнд болно</i></p> <p><i>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</i></p>
<p><b>ТӨӨЗ 2.3</b></p>	<p>Тендерг оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерг оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна.</p>
<p><b>ТӨӨЗ 6.2</b></p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах багцаас бүрдэнэ. Үүнд:</p> <p><i>Багц-1 Электрон бараа, барилгын материал -6,5 сая төгрөг          Багц-2 Модон эдлэл, барилгын материал -5,3 сая төгрөг</i></p>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нийлүүлэх бараа, материал нь холбогдох стандарт, чанарын шаардлага хангасан, дор дурдсан үзүүлэлт, үйлдвэрлэгч, өөр төрөлтэй дүйцэхүйц байх бөгөөд баталгаат хугацаа 12 сараас багагүй байна. Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа бүтээгдэхүүний дэлгэрэнгүй мэдээлэл, үзүүлэлт, тайлбар, фото зургийг тендерийн хамт ирүүлнэ.


№	Материалын нэр, загвар	Үзүүлэлт	Тоо ширхэг	Хэмжих нэгж
<b>Багц-1 Электрон бараа, барилгын материал</b>				
1	Телевизор /45инч/	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
2	Жижиг ширээ	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
3	Тэргэнцэртэй жинлэх жин	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
4	Эйр кондишн	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
5	Сувилагч сандал	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
6	Үйлчлүүлэгчийн сандал	Техникийн тодорхойлолтын дагуу	2	Ширхэг
7	Тарианы тэргэнцэр	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
8	Холигч /Ком/	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
9	Вакум цонх	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
10	Цонхны туузан хөшиг	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
11	Ханын залгуур, разетка	Техникийн тодорхойлолтын дагуу	2	Ширхэг
12	Уртасгагч	Техникийн тодорхойлолтын дагуу	2	Ширхэг
13	Таазны гэрэлтүүлэг	Техникийн тодорхойлолтын дагуу	2	Ширхэг
14	Суултуур /том хүнийх/	Техникийн тодорхойлолтын дагуу	2	Ширхэг
15	Угаалтуур	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
16	Холигч	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
17	Өнгөт хавтан	Техникийн тодорхойлолтын дагуу	2	Ширхэг
18	Будаг	Техникийн тодорхойлолтын дагуу	43	Ширхэг
19	Замаск	Техникийн тодорхойлолтын дагуу	110	Кг
20	Будаг шингэлэгч	Техникийн тодорхойлолтын дагуу	2	Литр







21	Багс /том/	Техникийн тодорхойлолтын дагуу	3	Ширхэг
22	Багс /жижиг/	Техникийн тодорхойлолтын дагуу	4	Ширхэг
23	Өнхрүүш	Техникийн тодорхойлолтын дагуу	4	Ширхэг
24	Вакум цонхны хавтан	Техникийн тодорхойлолтын дагуу	0,68	м2
25	Шпатель	Техникийн тодорхойлолтын дагуу	5	Ширхэг
26	Өнхрүүшний үс	Техникийн тодорхойлолтын дагуу	4	Ширхэг
27	Хөөс	Техникийн тодорхойлолтын дагуу	4	Ширхэг
28	Гипс	Техникийн тодорхойлолтын дагуу	2	Кг
<b>Нийт тоо ширхэг</b>			<b>204,68</b>	
<b>Багц-2 Модон эдлэл, барилгын материал</b>				
1	Буйдан	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
2	Ханын шүүгээ, хувцасны шүүгээ	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
3	Сувилагч ширээ /Бичгийн/	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
4	Гал тогооны гарнитур	Техникийн тодорхойлолтын дагуу	1	Ширхэг
5	Цемент	Техникийн тодорхойлолтын дагуу	3	Кг
<b>Нийт тоо ширхэг</b>			<b>6</b>	





БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ГЕМОДИАЛИЗЫН ТАСГИЙН  
 ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АМРАЛТЫН ӨРӨӨНИЙ ТОХИЖИЛТОД ШААРДЛАГАТАЙ  
 ТАВИЛГА ЭД ХОГШЛЫН ТЕХНИКИЙН ТОДРХОЙЛОЛТ, ХҮЧИН ЧАДАЛ, ҮЗҮҮЛЭЛТ,  
 ТОО ХЭМЖЭЭ

2020.01.02



**Нийт төсөв: 10 362 400**







№	Хэрэгслийн нэр төрөл	Хэрэгслийн зураг	Барааны тодорхойлолт	Тоо хэмжээ
1	Буйдан		Хэмжээ: Урт-3.2 метр Материал: Даавуун Чанар: Хүний биед хор нөлөөгүй материалаар хийгдсэн	1
2	Телевизор 45 инч		Дэлгэц 45 инч Дэлгэцийн нягтрал 1920*1080 Full HD Дүрс хурд 60Hz Холболтууд: HDMI USB WIFI (PC mall)Сургалт хийх зориулалттай	1
3	Жижиг ширээ		Материал: Нано технологигоор хийгдсэн цэвэр мод Хэмжээ: 750*389*752	1
4	Тэргэнцэртэй жинлэх жин		Даац: 159 кг Өндөр байх хэмжээ: 1950*540*880мм Нам байх хэмжээ: 1950*540*480мм Жин:45 кг	1




5	Ханын шүүгээ, хувцасны шүүгээ		Хувцасны шүүгээ болон баримт бичгийн тавиур бүхий 8,8м2 хэмжээтэй	1
6	Эйр кондишн		Ангилал: Хөргөлт/Агааржуулах Хөргөх хүчин чадал: 4.5-16 /кВ/ Халаах хүчин чадал: 5.0-18.0 /кВ/ Хөргөх ба халаах хүчин чадал: 1.7-6.0 /HP/	1
7	Сувилагч ширээ /бичгийн/		Нэршил: Бичгийн ширээ Хэмжээ: 90*52*73см Онцлог: Тасалгаа хэрэглээндээ тохируулж болно Далд утасны оруулгатай	1
8	Сувилагчын сандал		Чанар: Уян хатан шинжтэй, нуруу амраагчтай, Материал: Сайн чанарын даавуун материалаар хийгдсэн Хэмжээ: Онцлог: 4 дугуйтай тасалгаандаа чөлөөтэй хөдлөх чадамжтай	1
9	Үйлчлүүлэгч ийн сандал		Хийц: Түшлэгтэй, Материал: Даавуу, суудлын давцан зөөлөвчтэй Өнгө: Хар	2
10	Тарианы тэргэнцэр		Чанар: Зэвэрдэггүй гангаар хийгдсэн Хэмжээ: 800*470*900мм Хийц: Бохир хаях савтай, 2 давцантай	1
11	Гал тогооны гарнитур		Хэмжээ: 3м2 Өнгө: Цагаан Чанар: Модон	1
12	Холигч /ком/		Хэлбэр: Уян, зэвэрдэггүй ган төмрөөр хийгдсэн Чанар: Тросон ороолттой Чадал: Халуун, хүйтэн усных 1.2 м урттай	1

13	Вакум цонх		Хэмжээ: 3,74м2 Хэлбэр: 1 салхивчтай Өнгө: Цагаан Материал: Амьсгалдаг вакум чанартай	1
14	Цонхны туузан хөгшиг		Хэмжээ: 4 м2 Өнгө: Шаргал Чанар: Нарны шууд туяаны хамгаалттай Хэлбэр: Хагас болон бүтэн хаагддаг	1
15	Ханын залгуур, разетка		Брэнд: HPSHn ил разетка Чадал: 16А, 250в Өнгө: Шаргал, цагаан	2
16	Уртасгагч		5метрийн урттай, олон салаалгатай	2
17	Таазны гэрэлтүүлэг		Хэмжээс: Нэмэх хэлбэрийн 4 ширхэг лаптай Чадал: Лед гэрэл	2

ДОРНОД  
АЙМАГ ДАХЬ

№	Хэрэгслийн нэр төрөл	Хэрэгслийн зураг	Барааны тодорхойлолт	Тоо хэмжээ
1	Суултуур том хүнийх	 <p>LZ1202 LZ1202L</p>	<p>Чанар: Доошоо шууд урсах холболттой, 5 литрийн ус хадгална, усыг 2 урсгалтай дамжуулна Өнгө: Цагаан Хийц: Шаазан</p>	2
2	Угаалтуур		<p>Чанар: Доошоо шууд урсах холболттой, халуун хүйтэн усны оролттой Өнгө: Цагаан Хийц: Шаазан</p>	1
3	Холигч		<p>Чанар, хийц: Зэвэрдэггүй ган төмрөөр хийгдсэн, халуун хүйтэн усных Өнгө: Никель</p>	1
4	Өнгөт хавтан		<p>Хэмжээ: 2.5 м урттай, 1.2м өргөнтэй Өнгө: Цайвар цагаан, шаргал Чанар: Хүний биед хор нөлөөгүй сайжруулсан шахмал мод</p>	2

5	Будаг		Хэмжээ: 10 литр, 1 литр Чанар: Хүний биед хор нөлөөгүй Өнгө: Цагаан будаг 10 литр, шар будаг 1 литр	43
6	Замаска		Чанар: Хүний биед хор нөлөөгүй, наалдамхай чанартай, угаадаг Өнгө: Цагаан Хэмжих нэгж - кг	110
7	Будаг шингэлэгч		Хэмжээ: 1 литр Чанар: Хүний биед хор нөлөө багатай, шилэн савалгаатай Өнгө: Тунгалаг	2
8	Багс том		Хэмжээ: 10 см өргөнтэй, 25 см урттай Чанар: Зөөлөн өтгөн үстэй Өнгө: Шаргал	3
9	Багс жижиг		Хэмжээ: 6 см өргөнтэй, 20 см урттай Чанар: Зөөлөн өтгөн үстэй Өнгө: Шаргал	4
10	Өнхрүүш		Хэмжээ: 25 см урттай Чанар: Сайжруурсан хиймэл үстэй, бариултай	4
11	Вакум цонхны хавтан		Чанар: Хуванцар хавтан Өнгө: Цагаан Хэмжих нэгж-м2	0.68
12	Шпатель		Хэмжээ: 8 см өргөнтэй, 10 см урттай Чанар: Уян, хатуулаг материалтай Өнгө: Цагаан	5

13	Өнхрүүшний үс		Хэмжээ: 25 см урттай Чанар: Сайжруурсан хиймэл үстэй	4
14	Хөөс		Чанар: Өөрөөсөө шахагч хошуутай, хатуулаг барицалдах чанар сайн, мөөгөнцөрт тэсвэртэй Савалгаа: Лаазтай	4
15	Цемент		Хэмжээ: Ууттай 50 кг Чанар: Барьцалдах чадвар сайн	3
16	Гипс		Хэмжээ: Ууттай 30 кг Чанар: Зуурамтгай, барьцалдах санартай Өнгө: Цагаан	2



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА Ч.НЭРГҮЙ ТАНАА**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
4. Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>[тоо]</i> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <i>[ГТН-д заасан тоо]</i> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах        | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн  $[moo]^1$  хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup>**
- 9.1. Алданги оногдуулах хувь:  $[moo]$
- Алдангийн нийт дүн:  $[moo]$

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*